



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



JAPAN INTERNATIONAL
COOPERATION AGENCY

Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (DPUB)

Мэдээллийн хүртээмжийн семинар зохион
байгуулагдлаа (2018.06.19)



*Оролцогчид STB төхөөрөмжийн танилцуулгыг
идэвхтэй сонсож байлаа.*

6-р сарын 14-ний өдөр "Дохионы орчуулга болон бичгэн тайлбартай телевизийн нэвтрүүлгийг нэмэгдүүлэх нь" сэдвээр мэдээллийн хүртээмжийн семинар зохион байгууллаа. Семинарын үеэр Японы ASTEM ХК-ны төлөөлөгчид Set Top Box (STB) төхөөрөмжийн функц, ашиг тусын талаар танилцуулга хийв. STB төхөөрөмжийг зурагттай холбосноор дохионы хэлний орчуулга, бичгэн болон дуут тайлбарыг оруулах боломжтой. Өөрөөр хэлбэл дохионы хэлний орчуулга, бичгэн тайлбарыг интернэтээр дамжуулж хэрэглэгчдэд хүргэх тогтолцоо юм. STB төхөөрөмж хэрэглээнд нэвтэрснээр дохионы хэлний орчуулагч, бичгэн нь заавал телевизийн эфирт очиж ажиллах шаардлагагүй болох ба өөр газраас мэдээллээ хүргэх боломжтой болно. Мөн мэдээлэл хүлээн авч буй хэрэглэгчид дохионы хэлний орчуулгын хэмжээ, байршил, бичгэн тайлбарын өнгө, хэмжээг удирдлагаараа өөрчлөх боломжтой. 1995 оны Ханшин Аважи газар хөдлөлтийн үеэр сонсголын бэрхшээлтэй олон хүмүүс мэдээлэл авч чадаагүй ба үүнээс үүдэн энэ STB төхөөрөмжийг зохион бүтээсэн нь өдгөө дэлхийн олон оронд нэвтэрч байна. ASTEM ХК-ны танилцуулгын дараа "Энэ төхөөрөмжийг Монголд нэвтрүүлэх боломжтой юу? Ямар тогтолцоо хэрэгтэй вэ?" гэх мэт олон асуудлын оролцогчидтой санал солилцсон бөгөөд семинарт нийтдээ 80 гаруй хүн оролцлоо.

Хүртээмжийн үнэлгээний тайлангийн хурал
2018.06.13

6-р сарын 13-ны өдөр ХНХЯ-д зохион байгуулагдсан Хүртээмжийн үнэлгээний тайлангийн хуралд ТББ, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн байгууллагынхан, DPUB төслийн хамт олон гээд ойролцоогоор 70 хүн оролцлоо. Тус хурлыг ХНХЯ-ны газрын дарга С.Тунгалагтамир удирдан явуулсан бөгөөд эхлээд төслийн ахлах зөвлөх Чиба Монгол Улсын хүртээмжийг сайжруулах үйл ажиллагааны зураглал, тулгамдаж буй асуудлуудын талаар танилцууллаа. Дараа нь 5-6-р сард Хөдөлмөр, нийгмийн хамгааллын байгууллагуудад хүртээмжийн үнэлгээ хийсэн 3 ТББ-ынхан тайлангаа тавьж, цаашид хүртээмжтэй орчинг хэрхэн сайжруулах талаар хэлэлцүүлэг хийлээ. Цаашид төр, төрийн бус байгууллага, барилгын салбарынхан хамтраад хүн бүрт ээлтэй орчинг бүрдүүлэн ажиллах нь нэн чухал юм.



*ТББ-ууд үнэлгээний
тайлангаа тавив.*



JICA DPUB фэйсбүүк хуудсанд **LIKE** дарж нэгдээрэй!!

Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **2475** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.

**NTV телевизээр Хүртээмжийн үнэлгээний тайлангийн
хурлын мэдээлэл цацагдлаа
2018.06.15**

ХНХЯ, JICA/DPUB төсөлтэй хамтран зохион байгуулсан Дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээний тайлангийн хурлын тухай мэдээлэл NTV телевизээр цацагдлаа. Энэ удаа ХБИ-ийн ТББ-ууд Нийгмийн даатгалын хэлтэс, Гэр бүл, Хүүхэд Залуучуудын газар гэх мэт байгууллагуудад хийсэн үнэлгээний үр дүн, авах шаардлагатай арга хэмжээний талаар тайлагнасан юм. Холбогдох байгууллагуудын албан хаагчид тус хуралд идэвхтэй оролцсон бөгөөд JICA/DPUB төслийн зүгээс дэд бүтцийн хүртээмжийг хэрхэн сайжруулах талаар танилцууллаа.

Цаашид төрийн албан байгууллагуудын хүртээмжтэй орчин сайжирч, хүн бүрт хүртээмжтэй болно гэдэгт итгэлтэй байна.
<https://www.facebook.com/ntvmn/videos/1900193336678499/>



(37-р минутаас 2 минут хагас)

**Түгээмэл Хөгжил
Бие даан амьдрах
төвийн тэргүүн
Ундрахбаяр
үнэлгээний үр дүнг
танилцууллаа.**

**Харилцаа холбооны зохицуулах хорооны даргатай
уулзалт зохион байгууллаа
2018.06.19**

6-р сарын 15-ны өдөр төсөл, ХНХЯ болон мэдээллийн хүртээмжийн семинар зохион байгуулахаар ирсэн Японы ASTEM ХК-ны төлөөлөгч нар Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Адьяасүрэнтэй уулзалдлаа. Уулзалтын үеэр төслийн зүгээс зохион байгуулсан семинарынхаа талаар тайлагнасан ба ASTEM ХК-ны зүгээс Set Top Box төхөөрөмжийн функц, ашиг тусын талаар танилцууллаа. Мөн ASTEM компаний ноён Кобаяши Монголчууд IPTV-ийг өргөнөөр хэрэглэж байгаа тул STB төхөөрөмжийг нэвтрүүлэхэд техникийн хувьд бүрэн боломжтойг тайлбарлалаа. Тус яриаг идэвхтэй сонссон Адьяасүрэн дарга "Харилцаа холбооны зохицуулах хороо нь ХБИ-ийн үндэсний зөвлөлийн гишүүн бөгөөд цаашид мэдээллийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр хүчин чармайлт гаргана ажиллана." хэмээж байлаа. Бид бүхнийг найрсгаар хүлээн авч уулзсанд талархал илэрхийлэе.



Уулзалтын дараа дурсгалын зураг татуулав.

НҮБ-д дахин ажиллах болсон тухай

ТББ-д ажиллаад 1 жил өнгөрсний дараа өөр ажил хийх талаар бодож эхэллээ. Камбож дахь ажил маань маш үр дүнтэй хэрэгжсэн боловч Засгийн газрын үйл ажиллагааг шүүмжлэхээс илүү тогтолцоо, бодлого боловсруулах ажилд оролцох нь илүү сонирхолтой юм шиг санагдсан. Ганцхан жилийн хугацаанд ТББ-д ажиллаад хангалттай туршлага хуримтлуулсан гэж хэлэхгүй ч гэсэн анхнаасаа ажиллахыг хүсэж байсан НҮБ-д ажилд орох юмсан гэж бодох болсон. НҮБ-д ороод Хөгжлийн бэрхшээлийн салбарт ажиллана гэдэг нь миний хийхийг хүссэн ажил мөн үү гэж эргэлзэж байсан ч дадлага хийх үед миний удирдагчаар ажиллаж байсан мэргэжилтэнтэй зөвлөлдөж үзлээ. Гэтэл дадлагын удирдагч маань энэ талаар бодож үзье гэсэн хариу өгөв. Ингээд 4,5 хоногийн дараа түүнээс "Боломж байгаа боловч, яахыг нь сайн мэдэхгүй байна. Удахгүй Бангкок зохион байгуулагдах олон улсын хуралд ирээрэй" гэсэн хариу ирсэн юм. Ингээд тус хурлын үеэр ноён Кавамүра Хирошигой танилцсан юм. Тэрээр мэдээллийн хүртээмжийн мэргэжилтэн бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэд хэрэглэх боломжтой мультимедиа ном (Дэйзи)-ыг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр ажиллаж ирсэн. Би ноён Кавамүрад өөрийн намтар, мөрөөдөл, зорилгын талаар танилцуулж НҮБ-д ажилламаар байгаагаа хэлсэн. Үр дүнд нь ноён Кавамүра намайг өөрийн ТББ-д ажилд авч, би тус байгууллагыг төлөөлж НҮБ-д ажиллахаар болсон. Энэ бол миний амьдралд тохиосон аз завшаан байлаа. Тухайн үед хөгжиж буй орнуудад ч гэсэн интернетийн хэрэглээ дэлгэрч эхэлж байсан хэдий ч ХБИ-ийн хэрэглээ төдийлөн их байгаагүй учраас Кавамүра мэргэжилтэн мэдээлэл харилцааны технологи ашиглаж тэрхүү нөхцөл байдлыг өөрчилөхөөр ажиллаж байсан юм. Гэвч хөгжлийн бэрхшээлийн салбарт технологийн мэргэжилтэн цөөхөн байсан ба энэ утгаараа байгалийн шинжлэх ухаанаар мэргэшсэн миний туршлага хэрэг болсон. Ингээд хөгжлийн бэрхшээлийн салбарт 6 сар дадлага хийснээс өөр туршлагагүй би НҮБ-ын Ази, Номхон далайн Эдийн засаг-Нийгмийн комиссын Нийгмийн хөгжлийн хэлтэст ажиллахаар боллоо. Энэ бүхэн НҮБ-д ажиллах зорилгоор компаниасаа гараад 4 жил хагас өнгөрсний дараа буюу 2001 онд болсон юм. (Үргэлжлэл бий...)



Төслийн ахлах зөвлөх Чибэ Хисао

DPUB Холбоо барих хаяг

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: [https:// www.facebook.com/jicadpub](https://www.facebook.com/jicadpub)

Цахим хуудас: [https:// www.jica.go.jp/project/ mongolia/015/index.html](https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html)

И-мэйл: dpub.jica@gmail.com